



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.28 № 02/35 ЧАТ-САТ/2014/06/СТИА-Т163

Зөрчил арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Батлан хамгаалахын анги салбаруудын 2013 оны санхүүгийн тайланд аудит хийхээр Монгол Улсын Ерөнхий аудиторын 2013 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 149 дүгээр тушаалаар баталсан боловч Зэвсэгт хүчний нийт 31 анги салбарын 2013 оны санхүүгийн тайланг аймаг, орон нутгийн аудитын байгууллагаар аудит хийлгүүлэхгүйгээр Үндэсний аудитын газарт ирүүлснийг аудитын явцад түүвэрт хамруулсан,
2. Зэвсэгт хүчний 016, 119, 338 дугаар ангиудын 2013 оны санхүүгийн тайланг аймаг, орон нутгийн Аудитын газруудаар аудит хийлгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг зөрчиж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, 28 дугаар зүйлийн 28.1-д “Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан ... албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасан заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн Албан шаардлага өгч байна. Үүнд:

1. Зэвсэгт хүчний 016, 119, 338 дугаар ангиудын 2013 оны санхүүгийн тайланг аймаг, орон нутгийн Аудитын газруудаар аудит хийлгээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2014 оны санхүүгийн тайланг аудитад бүрэн хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн нарийн бичгийн дарга З.Болдбаатар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Батсүх нарт даалгав.

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 25-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Г.ЮРА